

# MERIT ТӨСЛИЙН МЭДЭЭ

2020 оны 1-р сар | Сэтгүүл №1

## Гүйцэтгэлийн үнэлгээ

“Төрийн албаны тухай” хуулийн шинэчилсэн найруулга 2019 оны 1-р сараас мөрдөгдөж эхэлсэнтэй холбогдуулан MERIT төслийн орон нутгийн түнш байгууллагуудад хүний нөөцийн удирдлагын дэмжлэг үзүүлэх зорилгоор зөвлөх Вилл Гау 2019 оны 9-р сарын 26-наас 12-р сарын 20-ныг хүртэл хугацаанд ажиллалаа. Энэ удаагийн томилолтоор зөвлөх Вилл орон даяар шинээр мөрдөгдөж буй арга аргачлалыг үр дүнтэй ашиглах, хэрэглээг нэмэгдүүлэхэд удирдах албан хаагчдын чадавхыг сайжруулахад голлон анхаарч, нэмэлт арга аргачлал боловсруулж, зөвлөгөө өгөв.

Гурван сарын хугацаанд зөвлөх Вилл 4 аймгийн 104 удирдах албан хаагчидтай ажилласан бөгөөд албан хаагчдын ажлын гүйцэтгэлийг ил тод, тэнцвэртэй байдлаар үнэлэх арга барил болон субъектив хандлагаас зайлсхийх ур чадвараа сайжрууллаа.



Мөн түүнчлэн зөвлөх Вилл сургагч багш бэлтгэх сургалт явуулж, хамрагдсан сургагч багш нар цаашид 4 аймгийн 12,000 гаруй төрийн албан хаагчдад хүний нөөцийн сургалт, үйл ажиллагаа зохион байгуулах чадвартай боллоо. Эдгээр сургагч багш нар төрийн албан хаагчдын сургалт хөгжлийн төлөвлөгөө боловсруулах, гүйцэтгэлийн үнэлгээ хийх, шинээр томилогдсон албан хаагчдыг чиглүүлэх, шинэ ажил үүрэгт нь дасан зохицуулах хөтөлбөр хэрэгжүүлэх зэрэг чиглэлээр олон чухал мэдлэг, чадвар сурч авлаа.

## Үр дүнд суурилсан хяналт-шинжилгээ, үнэлгээний үндэсний хэмжээний сургалт хөгжлийн төлөвлөгөөний стратеги

MERIT төслийн туршлагатай зөвлөхүүдийн нэг Рэймонд Жервэй энэ оны 1-р сарын 13-23-ны өдрүүдэд Монгол Улсад 6 дахь удаагийн томилолтоор ажиллалаа. Тэрбээр Удирдлагын академийн Улсын салбарын удирдлагын тэнхимийн эрхлэгч Др. Н.Болдтой хамтран “Үр дүнд суурилсан ХШҮ-ний сургалт хөгжлийн төлөвлөгөө”-ний төсөл боловсруулж, ЗГХЭГ-ийн ХШҮДА-ын газарт танилцуулав. Уг стратегийн баримт бичигт ХШҮ хариуцсан албан хаагчдын чадавхыг бэхжүүлэх, сургагч багш бэлтгэх арга барилыг хослуулан ашиглахаар тусгаснаараа давуу талтай. Цаашид ЗГХЭГ болон Удирдлагын академитай хамтран уг баримт бичгийг илүү боловсронгуй болгох төлөвлөгөөг хэрэгжүүлнэ.



## Мега төслийн удирдлага



MERIT төслийн хүрээнд Монгол Улсад хамгийн олон удаа томилолтоор ажилласан туршлагатай зөвлөхүүдийн нэг Бренда Буше зургаа дахь удаагийн томилолтоороо Үндэсний хөгжлийн газар (ҮХГ)-т 2020 оны 1-р сарын 6-наас 31-ний хугацаанд ажиллалаа. Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын хувьд төрийн байгууллага хоорондын хамтын ажиллагаа, салбар дундын зохицуулалт, ажлын уялдаа холбоог бэхжүүлэхэд нь ҮХГ-т MERIT төслийн зүгээс дэмжлэг үзүүлэн хамтран ажиллаж байгаа билээ.

Зөвлөх Бренда уул уурхайн салбарт хэрэгжих эсвэл тодорхой хэмжээгээр тус салбартай уялдах мега төслийн стратеги төлөвлөлт хийх мэргэжилтнүүдийн чадавхыг сайжруулах тал дээр ажиллаж, салбарын онцлог нөхцөл байдал, тэргүүлэх чиглэлийн талаар ойлголт авахын тулд холбогдох албан хаагчидтай хэд хэдэн удаагийн уулзалт зохион байгуулж санал солилцлоо. Энэ үеэр зөвлөх Бренда мега төслийг удирдах Канад Улсын туршлагаас хуваалцаж, Монгол Улсын хэмжээнд нийгэм-эдийн засаг, байгаль орчны тогтвортой хөгжлийг дэмжихэд чиглэсэн тайлан боловсруулснаа танилцуулсан. Засгийн газрын түвшинд уг үйл ажиллагаанд хамаарах асуудлыг хэлэлцэх цаг үетэй түүний томилолтын хугацаа таарсан нь цаг үеэ олсон хэрэг байлаа.

## Нутгийн захиргааны байгууллагын албан хаагчдын манлайллын ур чадварыг дээшлүүлэх нь

MERIT төсөл “Дейл Карнеги Тренинг”-ийн албан ёсны франчайз эрх эзэмшигч “Карьер Эйд ХХК”-тай хамтран ажиллаж төслийн түнш байгууллагуудын албан хаагчдын мэргэжлийн ур чадварын хөгжилд үнэтэй хувь нэмэр орууллаа. Илтгэх урлаг, багаар ажиллах, амжилтад хөтлөх ур чадварууд, мэдлэгийн менежмент болон манлайлал зэрэг сэдвийн хүрээнд Манлайллын сургалтанд төслийн түнш дөрвөн аймгийн нийт 90 (үүнээс 51 эмэгтэй, 39 эрэгтэй) удирдах албан хаагчид хамрагдлаа.

Хоёр өдрийн турш оролцоонд тулгуурласан аргазүйгээр явагдсан уг сургалт нь албан хаагчдын манлайллын чадварыг сайжруулах, байгууллагын үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэхэд чухал ач холбогдолтой. Уг сургалтад хамрагдсанаар төрийн үйлчилгээний чанар, хүртээмж нэмэгдсэний зэрэгцээ албан хаагчдын багаар ажиллах чадвар сайжирч, харилцаа хандлага нь өөрчлөгдөж байгаа талаар сургалтанд хамрагдсан ажилтнууд дурдаж байв.





## Олон нийтийн хэлэлцүүлэг хийх аргагүй, үйл явц

Дундговь аймгийн Засаг даргын тамгын газар аймгийн хэмжээнд мөрдөгдөх уул уурхайн бодлогын баримт бичгийг шинэчлэн боловсруулах чиглэлээр техникийн туслалцаа авах хүсэлтэй байгаагаа MERIT төсөлд уламжилсны дагуу энэ чиглэлээр мэргэшсэн зөвлөх Жоан МакИвэн 2019 оны 12-р сарын 25-наас 2020 оны 1-р сарын 8-ны хугацаанд Монгол Улсад 5 дахь удаагийн томилолтоор ажиллалаа.

Зөвлөх Жоан холбогдох мэргэжилтнүүдэд уул уурхайн бодлогын баримт бичиг боловсруулах талаар менторинг зөвлөгөө өгснөөс гадна олон нийтийн хэлэлцүүлэг хийх сургалт явуулсан нь сургалтанд хамрагдагсад талуудын оролцоог жигд хангаж, санал зөвлөмжийг нь сайтар сонсож авах нь бодлогын баримт бичиг боловсруулахад ихээхэн чухал ач холбогдолтой тухай мэдлэг, ойлголтыг өгч чадлаа.

Монгол Улсад хариуцлагатай уул уурхайг хөгжүүлэхэд хувь нэмэр оруулах оновчтой бодлогын баримт бичиг боловсруулахад нь дэмжлэг туслалцаа үзүүлэх гэсэн түүний зорилго биеллээ олох нь дамжиггүй.



## Орон нутгийн жижиг дунд бизнес эрхлэгчид ба уул уурхайн ханган нийлүүлэлтийн сүлжээ



Уул уурхайн үйл ажиллагааны нөлөөлөлд өртсөн орон нутгийн хөгжилд жижиг, дунд бизнес (ЖДБ)-ийн оруулах хувь нэмэр асар их бөгөөд эдийн засгийг төрөлжүүлэн орлогын эх үүсвэрийг тогтвортой болгож, нутгийн иргэдийн амьдралын чанарыг сайжруулахад чухал ач холбогдолтой.

ЖДБ эрхлэгчдийг чадавхжуулах ажлын хүрээнд Монгол Улсад олон удаа томилолтоор ажилласан, туршлагатай зөвлөхүүдийн нэг Эрик Карлзен ШУТИС-ийн Бизнесийн удирдлага, хүмүүнлэгийн сургуультай хамтран Дорнод, Сүхбаатар аймгийн ЖДБ эрхлэгчдэд зориулсан практикт суурилсан сургалтын хөтөлбөрийг боловсруулсан. Уг хөтөлбөрийн дагуу туршилтын сургалтыг ШУТИС-ийн багш нар 2019 онд Дорнод аймгийн ЖДБ эрхлэгчдэд явуулсан нь амжилттай болсон бөгөөд энэ оны 1-р сарын 15-18-ны өдрүүдэд Сүхбаатар аймгийн ЖДБ эрхлэгчдэд явууллаа.

Сургалтанд хамрагдсан ЖДБ эрхлэгчид цаашид бизнесээ өргөжүүлж, орон нутагтаа үйл ажиллагаа явуулж буй уул уурхайн компаниудын ханган нийлүүлэгч болох, улмаар өөрсдийн үйлдвэрлэдэг бүтээгдэхүүн, үйлчилгээгээ нийлүүлж, уул уурхайн үйл ажиллагаанаас үр шим хүртэх боломжийг эрэлхийлэх талаар санал солилцов.

## Жендэрийн тэгш байдлыг хангах мэргэжилтэн, манлайлагчдын хоёрдугаар чуулга уулзалт



MERIT төслийн Жендэрийн мэргэжилтнүүдийн клубын үйл ажиллагааны хүрээнд жил бүр уламжлал болгон зохион байгуулагддаг Жендэрийн тэгш байдлыг хангах мэргэжилтэн, манлайлагчдын энэ удаагийн чуулга уулзалтыг Дундговь аймгийн ЗДТГ 2019 оны 12-р сарын 12-13-ны өдрүүдэд аймагтаа амжилттай зохион байгууллаа. Уг чуулга уулзалтад төрийн захиргааны төв болон нутгийн захиргааны нийт 12 байгууллагын 39 жендэрийн мэргэжилтэн, манлайлагчид (үүнээс 27 эмэгтэй, 12 эрэгтэй)

хуран чуулж, жендэрийн эрх тэгш байдлыг хангахад тус тусын байгууллагын хэрэгжүүлж буй үйл ажиллагаа, гарч буй ахиц дэвшил, цаашдын төлөвлөгөөний талаар санал солилцов. Уг үйл ажиллагааны үеэр төрийн албан хаагчдад жендэрийн дүн шинжилгээ хийх мэдлэг чадвар эзэмшүүлэх зорилготой, төрийн бодлого, хөтөлбөр, үйл ажиллагаа нь хүн амын ялгаатай бүлгүүдэд өөр өөрөөр тусаж болохыг харуулсан жишээ кейс бүхий “Ахисан түвшний жендэрийн дүн шинжилгээ” цахим сургалтын монгол хувилбарыг танилцуулсан бөгөөд энэхүү сургалтыг Канад Улсын Эмэгтэйчүүдийн аж байдлын яамнаас тус улсын төрийн албан хаагчдад зориулан гаргасан сургалтын хөтөлбөрт тулгуурлан, Монгол Улсын онцлогт тохируулан өөрчилж боловсруулсан юм.

Жендэрийн мэргэжилтнүүдийн клубын тухайн жилийн үйл ажиллагааны зохицуулагчаар төрийн захиргааны төв байгууллага, орон нутгаас тус бүр нэг төлөөлөл сонгогддог уламжлалын дагуу клубын 2020 оны зохицуулагчдыг УУХҮЯ болон Дундговь аймгийн ЗДТГ-ын төлөөллөөс сонгов. Гишүүдийн зүгээс MERIT төсөлд клубын үйл ажиллагаагаар дамжуулан Монгол Улсын төрийн албанд жендэрийн эрх тэгш байдлыг хангахад шаардагдах ур чадвар олгож, гишүүн байгууллагуудын жендэрийн талаарх мэдлэг ойлголтыг нэмэгдүүлэхэд байнга дэмжлэг үзүүлж ажилладагт талархал илэрхийлж байв.



### Сайдын нэрэмжит өргөмжлөл олгов

MERIT төслийн хүрээнд “Карьер Эйд ХХК” болон “Өөрчлөлтийн төлөөх эмэгтэйчүүд” ТББ нь Байгаль орчин, аялал жуулчлалын яам (БОАЖЯ)-ны удирдах албан хаагчдад зориулсан “Манлайлах урлаг ба жендэрийн мэдрэмж” сэдэвт цуврал сургалтын хөтөлбөрийг боловсруулж, 8 сарын турш үе шаттайгаар явуулсан билээ. Сургалтын үр дүнд албан хаагчид манлайллын ур чадвар, жендэрийн талаарх мэдлэг ойлголтоо бататгаж, өөртөө итгэх итгэлээ нэмэгдүүлж чадсан байна. Яамны зүгээс салбарын албан хаагчдыг чадавхжуулах, жендэрийн мэдрэмжтэй бодлого төлөвлөлтийг үйл ажиллагаандаа нэвтрүүлэхэд нь MERIT төслийн оруулсан хувь нэмрийг үнэлж 2020 оны 1-р сарын 13-ны өдөр Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын нэрэмжит өргөмжлөл олголоо.

## Байгаль орчны нөхөн сэргээлт

Төв аймгийн Заамар сумын нутаг дэвсгэрт олборлолт явуулдаг уурхайн үйл ажиллагаатай танилцах туршлага судлах аялалыг 2019 оны 9-р сарын 25-26-ны өдрүүдэд зохион байгуулав. Уг аялалаар байгаль орчны менежментийн шилдэг туршлагыг нэвтрүүлэн ажиллаж буй дотоодын уурхайн жишээтэй танилцсан нь онцлог үйл явдал болов. Алтны шороон ордын уурхай эрхэлдэг “Уулс Заамар” ХХК нь яам, агентлаг, нутгийн захиргааны байгууллагуудын төлөөлөл болон байгаль орчны байцаагчдаас бүрдсэн 45 хүний бүрэлдэхүүнтэй багийг хүлээн авч, уурхайгаа танилцуулсан. Аялалд оролцогчид тус компаний газрын нөхөн сэргээлтийн чиглэлээр шагнал хүртсэн шилдэг туршлагатай танилцаж, нутгийн захиргааны байгууллагууд, уурхайн эргэн тойрны бүс нутагт амьдран суудаг иргэдтэй хэрхэн үр дүнтэй хамтран ажилладаг арга барилаас нь суралцав.



Уурхайн талбайтай танилцсаны дараа MERIT төслийн зөвлөх Росс Экклэс, Стив Аткин болон ХААИС-ийн профессор Ш.Түмэнжаргал нар оролцогчдын дунд хэлэлцүүлэг өрнүүлж, оролцогчид өөр өөрийн орон нутагт техникийн болон биологийн нөхөн сэргээлт хийгдэж буй практикийг сайжруулахад тулгардаг хүндрэл бэрхшээл, боломжийн талаар санал бодлоо нээлттэй солилцов. Мөн энэ үеэр уул уурхайн компани болон нутгийн захиргааны байгууллага хоорондын харилцаа, хамтын ажиллагаанд тулгардаг асуудал, мэдээллийн зөрүүтэй байдлын талаарх сэдэв хөндөгдөж байсан нь оролцогчид уул уурхайн компаний төлөөлөлтэй хэрхэн хамтарч ажиллах талаараа санал бодлоо солилцох боломжийг бүрдүүлсэн юм. Уг туршлага судлах аялал нь оролцогчдын дунд уул уурхайн салбарын үйл ажиллагаанд эерэгээр хандах өөрчлөлтийг авчирч чадсан үйл явдал боллоо.

## Оролцоонд суурилсан жендэрийн аудит

MERIT төсөл байгууллагын хэмжээнд оролцоонд суурилсан жендэрийн аудит хийхэд ШУА-ийн харьяа Газарзүй-геоэкологийн хүрээлэн (ГГХ)-тэй 2019 оны 9-р сарын 9-нөөс 10-р сарын 4-ний өдрүүдэд хамтран ажиллав.

MERIT төсөл тус хүрээлэнтэй жендэрийн тэгш байдлын үзэл баримтлалыг байгууллагын бодлого төлөвлөлт, үйл ажиллагаа, ХШҮ-нд тусгах чиглэлээр 2017 оноос хойш хамтран ажиллаж байгаа бөгөөд тухайн байгууллага дахь жендэрийн нөхцөл байдлыг үнэлж, давуу талыг тодорхойлох, цаашид сайжруулах чиглэл, боломжийг тодорхойлох зорилгоор оролцоонд суурилсан энэхүү аргачлалыг ашиглан аудит хийв.

Байгууллагад мөрдөгдөж буй баримт бичгийн судалгаа, асуулга, байгууллагын бүхий л түвшний албан хаагчидтай уян хатан, нээлттэй ярилцлага өрнүүлэх зэрэг судалгааны аргачлал ашиглан хийсэн жендэрийн аудитад хүрээлэнгийн удирдлага, албан хаагчид идэвхтэй оролцлоо. Аудитын зөвлөмжийг хэрэгжүүлэхээр ГГХ-ийн удирдлага, жендэрийн клуб бидэнтэй хамтран ажиллаж байна.



Global Affairs  
Canada

Affaires mondiales  
Canada

МЕРИТ төсөл нь **Канадын Гадаад Хэргийн Яамны санхүүжилтээр** болон Канадын хоёр төрийн бус байгууллага, Канадын мэргэжлийн үйлчилгээний байгууллага (**CESO**) болон Канадын дэлхийн их сургуулийн үйлчилгээ (**WUSC**) хоорондын түншлэлээр хэрэгжиж байна.

### БИДЭНТЭЙ ХОЛБОО БАРИХ



info@merit.mn



www.merit.mn



+976 7016-5000



Монгол Улс, Улаанбаатар-15160  
Чингэлтэй дүүрэг, 1-р хороо,  
Худалдааны гудамж,  
Нейшнл Таймс Нюс Тауэр,  
3-р давхар